

ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮССЭН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЖУРАМ

Нэг. Үндэслэл

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудад дүн шинжилгээ хийх, шалтгааныг тогтоох, мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой асуудлыг энэ журмаар зохицуулна.

Хоёр. Зорилго

Зоонозын халдварт өвчний үед мэргэжлийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, давтан гарахаас сэргийлэх, харилцан суралцах замаар тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад оршино.

Гурав. Хамрах хүрээ

ЗӨСҮТ-ийн албадууд болон Нийслэл, аймгийн ЗӨСТ-үүд хамаарна.

Дөрөв. Нэр томьёо

Зоонозын шалтгаант халдварын үед мэргэжлийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйл явцыг **тохиолдол** гэнэ.

Тав. Үүрэг, оролцоо

Албан тушаал	Үүрэг
Захирал	Журмыг батлах
Чанарын алба	Журмын хэрэгжилтийг хангуулах, Мэдээлэгдсэн тохиолдлыг ангилан цаашид авах арга хэмжээний чиглэлийг гаргана
Албадын дарга нар	Алдах дөхсөн тохиолдол-1А, тохиолдол-1Б гэж бүртгэн албаны түвшинд хэлэлцэн үндсэн шалтгааныг тодорхойлж авсан хариу арга хэмжээг ЧАБХҮА-нд мэдээлнэ
Албан хаагч	Тохиолдлыг мэдээлэх, давтан гарахаас сэргийлэх

Зургаа. Тохиолдлын ангилал

Алдах дөхсөн тохиолдол – Үйлчлүүлэгчид хохирол учруулж болзошгүй

6.2 Тохиолдол – Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй байдлыг

6.3 Таагүй тохиолдол – Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчид сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдлыг

Ноцтой тохиолдол – Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгч ноцтойгоор хохирох, эсвэл амь насаа алдахад хүргэсэн үр дагаврыг
Эмнэлгийн алдаа – Төлөвлөсөн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх эсвэл буруу төлөвлөн хэрэгжүүлсэн, зөв төлөвлөсөн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэн үйлдлийг

Долоо. Тохиолдлыг бүртгэх, мэдээлэх ерөнхий зарчим

7.1 Байгууллагын албан хаагч бүр тохиолдлыг шуурхай мэдээлэх үүрэгтэй

7.2 Мэдээлэлд дүн шинжилгээ хийлгүйгээр албан хаагчийг тохиолдолтой холбоотой ажлын гүйцэтгэлийг үнэлэхгүй

Тохиолдлыг мэдээлэх, бүртгэх, үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх бүхий л үйл ажиллагааг баримтжуулсан байна

Тохиолдлыг илрүүлэн мэдээлсэн ажилтныг зэмлэн буруутгах бус эерэг бүтээлч арга замаар асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагаанд оролцсонд тооцно

ЗӨСҮТ болон ЗӨСТ-үүд нь тохиолдлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх бөгөөд Чанарын алба/ баг нь тохиолдлыг дахин давтан гаргахгүй байх, дараагийн гарч болзошгүй эрсдэлд үнэлгээ хийн, чанар сайжруулах арга хэмжээг зохион байгуулна.

Найм. Тохиолдлыг ангилах, бүртгэх, мэдээлэх

8.1 Тохиолдлыг анх харсан, оролцсон, илрүүлсэн ажилтан ноцтой тохиолдлыг 24 цагт, бусдыг 72 цагийн дотор бүртгэж мэдээлнэ

8.2 Мэдээлэгдсэн тохиолдлыг Чанарын алба/ баг ангилан цаашид авах арга хэмжээний чиглэлийг гаргана

"Алдаа дөхсөн тохиолдол" 1А гэж ангилан бүртгэж, алба/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг Чанарын алба/ багт мэдээлнэ

8.4 "Тохиолдол" 1Б гэж ангилан бүртгэж, алба/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг Чанарын алба/багт мэдээлнэ

"Таагүй тохиолдол" 2, гэж бүртгэн Чанарын алба/ багийн түвшинд үндсэн шалтгааныг тодорхойлон хэлэлцэж, байгууллагын удирдлагад мэдээлнэ

8.6 "Ноцтой тохиолдол" 3 гэж бүртгэн Чанарын алба/ багийн түвшинд үндсэн шалтгааныг тодорхойлон хэлэлцэж, байгууллагын удирдлагад мэдэгдэн Тохиолдол, эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан <https://eburtgel.hdc.gov.mn/> -д мэдээлнэ

Тохиолдлын нэгдсэн сангийн ажиллах журмыг баримтлан эрүүл мэндийн байгууллагын Чанарын алба/багийн мэргэжилтэн мэдээлэл илгээнэ

"Эмнэлгийн алдаа" гэж тогтоогдсон бол холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ

Нийгмийн сүлжээгээр түгээгдсэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээллийг Чанарын алба/баг нь тохиолдол гэж бүртгэх бөгөөд дүн шинжилгээ хийж хариу арга хэмжээ авна

8.10 1А, 1Б ангилалд хамаарах тохиолдлыг алба/нэгжид сургалт зохион байгуулах, тохиолдол гаргах шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг арлгах, эрсдэлээс сэргийлэх зэрэг арга хэмжээ авна

8.11 3 ангилалд хамаарагдаж байвал Чанарын алба/баг нь дүн шинжилгээний багийг зохион байгуулна.

Ес.Хавсралт

9.1 Тохиолдлын үр дагаврын ангилал, мэдээлэх түвшин

9.2 Тохиолдлыг тасаг/нэгжид бүртгэх хуудас

9.3 ЧА-аас тасаг/нэгжид цохогдох хуудас /1А, 1Б тохиолдолд хөтөлнө/

9.4 ЧА-д хөтлөгдөх тохиолдлын хуудас

DRAFT

Тохиолдлын үр дагаврын ангилал, мэдээлэх түвшин

Ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Зэрэглэл	Тохиолдлын үр дагаврын ангилал	Авах арга хэмжээ, мэдээлэл түвшин
Алдах дөхсөн тохиолдол	Хор хөнөөлд хүргэж болзошгүй байсан ч таслан зогсоосон үйлдэл	1А	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид гэмтэл учруулаагүй, аюулгүй байдал, байгууллагын нэр хүндэд нөлөөлөөгүй	Алба/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг Чанарын алба/багт мэдээлнэ
Тохиолдол	Анхаарал татсан нөхцөл байдал үүсэх	1Б		
Таагүй тохиолдол	Тусламж үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчид сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдал үүсэх		Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт, гэмтлийн хэмжээ бага	Чанарын алба/багийн түвшинд үндсэн шалтгааныг тодорхойлон хэлэлцэж, байгууллагын удирдлагад мэдээлнэ
Ноцтой тохиолдол	Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөнд бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах, эсвэл амь насаа алдахад хүргэсэн ямар нэг урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүсэх		Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт үзүүлсэн, хор уршиг учруулаагүй боловч гомдоосон, байгууллагын нэр хүндэд нөлөөлсөн	Чанарын алба/багийн түвшинд үндсэн шалтгааныг тодорхойлон хэлэлцэж, байгууллагын удирдлагад мэдэгдэн Тохиолдол, эрсдэлийн м э д э э

Тохиолдлыг нэгжид бүртгэх хуудас

А хэсэг. Ажилтан бөглөнө.

Байгууллагын нэр:

Тохиолдол болсон байршил:

.....

Цаг: огноо: он сар өдөр

Тохиолдсон явдал:

.....

.....

.....

.....

.....

Мэдээлсэн ажилтан:
/нэр/ /гарын үсэг/

Танилцсан: ЧХББА-ны аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер:

.....
/нэр/ /гарын үсэг/

ЧХББА-аас тасаг/нэгжид цохогдох хуудас /1А, 1Б тохиолдолд хөтөлнө

Б хэсэг. **Хамаарах тасаг/нэгжид илгээнэ.**

Тохиолдлын №

Тасаг/нэгжийн нэр:

Шалтгаан: Хувь хүнтэй холбоотой ☐ Тогтолцоотой холбоотой ☐Тохиолдлын зэрэг: 1А ☐ 1Б ☐Тохиолдлын үндсэн шалтгаан: /журмын 1.3-ыг харна/
.....
.....
.....
.....
.....Нөлөөлөх хүчин зүйл: /журмын 1.4-ыг харна/
.....
.....
.....
.....
.....

Тасаг/нэгжээс авсан арга хэмжээ:

Алба, тасгийн дарга:

/нэр/

/гарын үсэг/

Танилцсан: ЧХББА-ны аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер:

.....

/нэр/

.....

/гарын үсэг/

..... он сар өдөр

ЧХББА-д хөтлөгдөх тохиолдлын хуудас

Тохиолдлын №

Тасаг/нэгжийн нэр:

Тохиолдсон явдал:

.....

.....

.....

Тохиолдлын зэрэг: /журмын 1.2; 2.9-ийг харна/

☐1А ☐1Б ☐2 ☐3 ☐ Нийгмийн сүлжээгээр түгээгдсэн.

Шалтгаан: /журмын 1.3-ыг харна/ 1 2 3 4 5

Нөлөөлөх хүчин зүйл: /журмын 1.4.-ыг харна/ 1 2 3 4 5 6

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Чанар сайжруулах арга хэрэгсэл:

.....

.....

.....

.....

.....

Эргэх холбоо: /дугуйлна уу/

1. Байгууллагын удирдлагад
2. Тохиолдол мэдээлсэн ажилтанд
3. Үйлчлүүлэгч, түүний ар гэрт
4. Холбогдох эрүүл мэндийн байгууллагад

ЧХББА-ны дарга: /гарын үсэг/

..... он сар өдөр